

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ф.БАЯРСАЙХАН

АВТО ЗОГСООЛ (СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 12, 13, 15, 16 ДУГААР
ХОРОО)-ЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Ерөнхий зүйл	Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 15, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт авто зогсоол шинэчлэх ажил Зөвлөх компани: Тусгай зөвшөөрөлтэй компани - Инженер геодезийн ажлын тайлан - Авто зам, замын байгууламжийн техникийн зураг - Тайлбар бичиг (ажлын нэр, тоо хэмжээ, зураг төслийн иж бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөлүүд гэх мэт) - Техникийн шаардлага - Авто зам, замын байгууламжийн төсөв (магадлалаар оруулах)
2	Барилгын талбайн үзүүлэлт	Одоо зогсоол нь эвдрэлтэй, зарим хэсэгт хучилтгүй бөгөөд нөхцөл байдалд уялдуулан шинэчлэх, шинээр барих
3	Ажлын цар хүрээ	1. Зураг төсөл боловсруулахдаа авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах техникийн даалгаврыг үндэслэх 2. Төсвийг магадлалаар оруулах
4	Ажлын хил хязгаар	Төсөлд Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 15, 16 дугаар хорооны зам талбай хамаарна. Техникийн даалгаврын хавсралтаас байршлыг харах.
5	Барилгын ажлын зохион байгуулалт	1. Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журмын дагуу зөвшөөрөл авна. 2. Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд гүйцэтгэгч нь ажлын талбайн аюулгүй байдлыг ханган ажиллана. 3. Гүйцэтгэгч нь газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах, шинээр хийх ажлыг хариуцна. Үүнд: цахилгаан, холбоо, борооны ус зайлуулах, гэрэлтүүлэг гэх мэт. 4. Гүйцэтгэгч нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил /байнгын болон түр ашиглах талбайг оролцуулан/-тай холбоотой дэвсгэр зургийг эрх бүхий байгуулагатай зөвшилцөж эцсийн байдлаар батлуулан захиалагчид хүлээлгэн өгнө. 5. Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг, тэмдэглэгээ г.м./-ыг бүрэн хангаж ажиллана. 6. Ажил гүйцэтгэх үедээ карьер нээх, хог хаягдал хаях, төвлөрсөн цэг нээх зэрэг ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудын талаар харьяалах дүүргийн засаг даргын албаны ажилтнууд болон байгаль орчны байцаагчтай харилцан зөвшилцөж ажиллана. 7. Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид, нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч хүн

		<p>хүч, машин механизмын хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>8. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна. Ажлыг батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу гүйцэтгэнэ.</p> <p>Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ явганаар зорчиж буй ард иргэдэд саад учруулахгүй байх.</p> <p>Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих нөхцөлийг ханган ажиллах, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалалтын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай.</p> <p>НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан "Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага"-ыг баримтлан гүйцэтгэнэ.</p> <p>9. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>10. Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баталгаажуулаагүй, 7 хоног тутмын тайланд тусгаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар ашиглана.</p> <p>11. Барилгын ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрт бэлтгэсэн түүхий эд, материал хэрэглэх бөгөөд захиалагч байгууллагаас зөвшөөрөл авсан үндсэн дээр гэрээ байгуулна.</p>
6	Бусад	Авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

ХЯНАСАН:

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Г.Баттогтох

БОЛОВСРУУЛСАН:

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн



Ц.Батжаргал

Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 15, 16 дугаар хороо, авто зогсоолын ажлын тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан

№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага /жил/
1	Авто замын инженер	1	2 болон түүнээс дээш
2	Геодезийн инженер	1	1 болон түүнээс дээш
3	Материалын инженер	1	1 болон түүнээс дээш
4	Хөдөлмөр хамгааллын инженер	1	1 болон түүнээс дээш

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизмууд:

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Усны машин	ш	1	1 тн	Өөрийн болон түрээс
2	Эксковатор /дугуйт/	ш	1	0.5 м3	Өөрийн болон түрээс
3	Автосамосвал	ш	2	10-18м3	Өөрийн болон түрээс
4	Бага оврын ачааны машин	ш	1	1 тн	Өөрийн
5	Асфальт дэвсэгч	ш	1	3.5-9.0 м	Өөрийн болон түрээс
6	Гөлгөр булт индүү	ш	1	4-8 тн	Өөрийн болон түрээс
7	Хийн дугуйт индүү	ш	1	10-16 тн	Өөрийн болон түрээс

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжүүд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Зөөврийн гагнуурын аппарат	шр	1	500а	Өөрийн
2	Гар нягтруулагч	шр	2	90кг, 120кг	Өөрийн
3	Босоо дэвхэрдэг нягтруулагч	шр	1		Өөрийн
4	Зөөврийн компрессор	шр	1	3 м3/мин	Өөрийн
5	Асфальтбетон зүсэгч болон чулуу зүсэгч хөрөө	шр	1	12 см	Өөрийн
6	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	ком	1		Өөрийн
7	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа				Хангалттай хэмжээгээр

8	Автомат нивелир, Теодолит /сүүлийн үеийн/	ком	1		Өөрийн
9	Зурган баримтжуулалт гүйцэтгэхэд шаардагдах рейк, метр, гадас, самбар	ком	1		Өөрийн

Хянасан:

Нийслэлийн Замын хөгжлийн газрын
ЗАХХ-ийн дарга

О.Энхбаатар

Нийслэлийн Замын хөгжлийн газрын
ЗАХХ-ийн ахлах мэргэжилтэн

Б.Ганбат

Боловсруулсан:

Нийслэлийн Замын хөгжлийн газрын
ЗАХХ-ийн мэргэжилтэн

Т.Чингэс

2023 оны 4 сарын 20-ний өдөр